



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,

Цахим хуудас: www.mongolbank.mn

2026. 09. 11 № А-1/806

танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.БАЯРМАА ТАНАА

Танаас 2026 оны 08 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн 49 дүгээр албан бичигтэй танилцлаа.

Таны хүсэлтийн дагуу Монголбанкнаас инфляцын өсөлт болон мөнгөний бодлогын үр нөлөөний талаарх мэдээллийг бэлтгэн, хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт 58 хуудастай.

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ



С.НАРАНЦОГТ

1526031805


Монголбанкны 2026 оны 09 дугаар сарын 11-ны өдрийн 11-дугаар албан бичгийн хавсралт

Гүйцэтгэх хураангуй. 2026 оны 7 дугаар сарын байдлаарх инфляцын өсөлтийн гол эх үүсвэр нь мах, хүнсний ногоо, шатахуун зэрэг нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлс байсан боловч эдгээрийн хоёрдогч нөлөө суурь инфляц, инфляцын хүлээлт, төгрөгийн өгөөжид дамжих эрсдэл нэмэгдсэн тул Монголбанк мөнгөний бодлогын хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Мөнгөний бодлого нь хүнс, шатахууны анхдагч үнийн өсөлтийг шууд бууруулах боломж хязгаарлагдмал хэдий ч зээл, дотоод эрэлт, ханш, инфляцын хүлээлтийн сувгаар дамжих инфляцын дам нөлөө, цаашдын эрчимжилтийг хязгаарлах үүрэгтэй.

1. 2026 оны 7 дугаар сарын байдлаарх 13.0 хувийн инфляцаас Монголбанкны мөнгөний бодлогоор нөлөөлөх боломжтой дотоод эрэлт, зээл, мөнгөний нийлүүлэлт, төгрөгийн ханш, инфляцын хүлээлт болон анхны үнийн өсөлтөөс бусад бараа, үйлчилгээнд дамжсан нөлөө нийлээд хэдэн нэгж хувийг бүрдүүлсэн талаарх холбогдох судалгаа, тооцоо, мэдээлэл, үнэлгээ, тайлбар.

Инфляц 2026 оны 7 дугаар сарын байдлаар 13.0 хувьд хүрсэн бөгөөд бүтцээр нь авч үзвэл мах, махан бүтээгдэхүүн, хүнсний ногоо зэрэг дотоодын хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт нийт инфляцын 6.5 нэгж хувийг буюу тал орчим хувийг бүрдүүлж байна. Мөн геополитикийн хурцадмал байдлын нөлөөгөөр дэлхийн зах зээл дэх нефтийн бүтээгдэхүүний үнэ өсөж, улмаар дотоодын шатахууны үнэ нэмэгдсэн нь инфляцыг 1.2 нэгж хувиар нэмэгдүүлэх нөлөө үзүүлсэн.

Зураг 1. Инфляц, бүрэлдэхүүн хэсгүүдээр



Эх сурвалж: YCX, Монголбанк

Монгол Улсад эрэлтийн шалтгаантай инфляцыг нийт инфляцаас ялган харуулдаг суурь инфляцын албан ёсны статистик мэдээлэл байхгүй байна. Харин үнийн түр зуурын болон нийлүүлэлтийн шинжтэй өөрчлөлтийн нөлөөг төлөөлүүлэн хүнс, шатахуун болон төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээг хэрэглээний сагснаас хасаж тооцсон суурь инфляцыг Монголбанк өөрийн бодлогын шинжилгээ, тооцоололд ашигладаг. Бидний энэ тооцооллоор суурь инфляц 2026 оны эхний хагаст харьцангуй тогтвортой байсан бөгөөд 7 дугаар сард 0.8 нэгж хувиар нэмэгдэж 6.9 хувьд хүрсэн нь зорилтог түвшний интервалд байна. Өөрөөр хэлбэл эрэлтийн шалтгаант үнийн өсөлт болон нийлүүлэлтийн шалтгаант үнийн өсөлтийн дам нөлөөг суурь инфляцын өөрчлөлтөөр хэмжиж болно. Гэхдээ МУ-ын онцлог болох бараа, бүтээгдэхүүний зах зээлийн дэд бүтэц, нийлүүлэлтийн болон логистикийн сүлжээ бүрэн хөгжөөгүй, найдвартай, тогтвортой ажиллаж чадахгүй байгаагаас нийлүүлэлтийн шалтгаант үнийн өсөлт олон бараа, үйлчилгээнд тухайлбал хүнснээс гадна хүнсний бус бараа, бүтээгдэхүүнд илрэх тохиолдолд цөөнгүй байдаг. Энэ нь суурь инфляц тооцох цар хүрээг нэмэгдүүлэх, тогтмол бүтэцтэй тооцоход зарим тохиолдолд учир дутагдалтай болгодог. Иймээс суурь инфляцын тооцоог олон төрлөөр тооцож тогтмол харьцуулан үзэх зэргээр эрэлтийн шалтгаант инфляцыг бүрэн танихад ашиглаж байна.

Мөнгөний бодлогын шинжилгээнд ашиглаж буй макро загварууд нь эдийн засгийн харилцан хамаарлыг агрегат түвшинд авч үздэг тул хүнс, шатахуун зэрэг тодорхой бүлгийн үнийн шокийн инфляцад үзүүлэх шууд болон дам нөлөөг нийлбэрээр нь тооцоолох боломжтой байдаг. Харин эдгээрийн дам нөлөөг бараа, бүтээгдэхүүн тус бүрээр нь нарийвчлан салгаж тооцох боломж хязгаарлагдмал юм. Тухайлбал, цөөнгүй хүнсний барааны үнийн өсөлт өнгөрсөн оны сүүлийн саруудаас эрчимжсэн тул үнийн өсөлтийг бараа тус бүрээр шууд болон дам нөлөөг бусад хүчин зүйлээс нарийвчлан салгах боломж хязгаарлагдмал байна.

Тодорхой бараа бүтээгдэхүүн эсхүл тодорхой бүлгийн үнийн өсөлтийн инфляцад үзүүлэх дам нөлөөг үнэлэхдээ ҮСХ-ноос тооцдог Орц-Гарцын хүснэгтэд үндэслэн тооцож, өөрсдийн тооцоололтой харьцуулан шалгадаг. Тухайлбал, шатахууны үнэ харьцангуй тогтвортой байсан тул сүүлийн үеийн үнийн өсөлтийн дам нөлөөг тооцох боломжтой. ҮСХ-ны орц-гарцын хүснэгтэд үндэслэн тооцоход шатахууны үнийн өсөлтийн шууд нөлөө 1.2 нэгж хувь, шатахууны үнийн өсөлтийн дам нөлөө 0.5 нэгж хувь байна.

Эдгээр тооцоолол нь тодорхой төрлийн үнийн шокийн инфляцад үзүүлэх нөлөөллийн хэмжээг тоймлон харуулах зорилготой бөгөөд салбар хоорондын дам нөлөөг харуулах нэмэлт тооцоо гэж хэлж болно. Нийлүүлэлтийн үнийн өсөлт, тухайлбал шатахууны үнийн өсөлт иргэдийн хэрэглээ, ААНБ-ын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын шийдвэрт харилцан адилгүй нөлөө үзүүлдэг. Үүнд орлогын түвшин, салбараас хамаарсан ашигт ажиллагаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Иймд иргэд, ААНБ-ын үйл хөдлөлд гарах өөрчлөлтийг бүрэн тооцох боломж хязгаарлагдмал тул дам нөлөө бодит байдал дээр тооцооллоос өндөр эсхүл бага байх боломжтой.

2. 2024 оны 1 дүгээр улирлаас 2026 оны 2 дугаар улирал хүртэл Монголбанкнаас боловсруулсан инфляцын 3, 6, 12 сарын төсөөллийг бодит гүйцэтгэлтэй харьцуулж, зөрүүний хэмжээ, гол шалтгаан, давтан дутуу болон хэтрүүлэн үнэлсэн хүчин зүйл, төсөөллийн алдаанд хийсэн дотоод үнэлгээ, алдааг залруулах чиглэлээр авсан арга хэмжээний талаарх холбогдох хүснэгт, судалгаа, тооцоо, мэдээлэл, тайлбар.

Ирээдүйн талаарх бүх мэдээлэл олдохгүй учраас төсөөлөл нь тухайн цаг хугацаанд мэдэгдэж буй боломжит чанарын болон тоон бүхий л мэдээлэл, томоохон ААНБ-ын бизнесийн төлөвлөгөө, МУ-

ын Засгийн газрын төсвийн төлөвлөгөө болон гадаад эх сурвалжуудын төсөөлөл зэрэгт үндэслэсэн олон тооны таамаглалт нөхцөл ашигладаг. Гэвч эдгээр ашигласан таамаглалт нөхцөлүүд байнга өөрчлөгддөг нь төсөөллийн алдааг голчлон бүрдүүлдэг. Мөн гадаад, дотоод урьдчилан тааварлашгүй гэнэтийн шок бий болох, бодлогын өөрчлөлтүүд гарах /төсөв тодотгох г.м/ зэргээс төсөөллийн зөрүү бий болдог. Тухайлбал, төсөөлөлд ашиглаж буй тухайн жилийн төсвийн зардлыг тооцохдоо УИХ-аас баталсан төсвийн дүнгээр, ирэх онуудын төсвийн зардлын хэмжээг төсвийн хүрээний мэдэгдлийн дүнгээр авч ашигладаг. Харин бодит байдал дээр тухайн жилийн төсөв тодотголоор нэмэгдэх, ирэх оны төсвийн үзүүлэлтүүд анх танилцуулж байсан хүрээний мэдэгдлийн дүнгээс давах зэрэг томоохон зардлын өөрчлөлтүүд ордог. Энэ нь нэг талаас эдийн засгийн гүйцэтгэл, төсөөлөлд өөрчлөлт орох гол шалтгаан болдог. Мөн сүүлийн жилүүдэд гэнэтийн тааварлашгүй гадаад, дотоод хавсарсан шокууд байнга тохиолдох болсон нь төсөөлөлд ихээхэн нөлөөлж байна. Үүний гол жишээ нь ОХУ-Украины дайн, Иран-АНУ-ын хурцадмал байдлаас үүдэлтэй шагахууны үнийн өсөлт, нийлүүлэлтийн тасалдал, 2023, 2024 оны дараалсан зуд, 2024 оны дотоодын цахилгааны үнийн огцом өсөлт, 2025 оны төмсний ургац огцом буурсан зэргийг нэрлэж болно.

Үүний зэрэгцээ аливаа бодлогын шинжилгээ, төсөөлөл боловсруулах аргачлалыг тогтмол шинэчлэн сайжруулаагүйгээс төсөөллийн алдаа үүсэх эрсдэл нэмэгддэг билээ. Эдгээр эрсдэлийг бууруулах үүднээс Монголбанк өөрсдөөс шалтгаалах төсөөлөл шинжилгээний үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулж байна. Дэлгэрүүлбэл:

Нэгдүгээрт, Монголбанк улирал тутам шинээр гарсан тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн инфляц болон бусад макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн богино, дунд хугацааны төсөөллөө шинэчилдэг. Шинэчлэх бүрд өмнөх улирлын төсөөллийн алдааны шинжилгээ хийж, төсөөллийн зөрүү, түүний учир шалтгааныг олон нийтэд 2024 оныг дуустал “Инфляцын тайлан”, 2025 оноос шинэчлэн сайжруулсан “Мөнгөний бодлогын тайлан”-д оруулан олон нийтэд нээлттэй танилцуулж Төв банкны ил тод байдлыг ханган ажиллаж байна. 2024 оны 1 дүгээр улирлаас 2026 оны 2 дугаар улирал хүртэл инфляцын төсөөллийг улирал бүр шинэчлэн нийтдээ 10 удаа төсөөллөө шинэчлэн танилцуулсан бөгөөд үр дүн, төсөөллийн зөрүүний талаар мэдээллийг тухай бүр “Инфляцын тайлан” болон “Мөнгөний бодлогын тайлан”-д оруулсныг доорх хүснэгтэд оруулан цахим холбоосыг байршууллаа. Сүүлийн 10 удаагийн төсөөллийг авч үзвэл ирэх 3 сарын инфляцын төсөөллийн гүйцэтгэлээс зөрсөн зөрүү дунджаар 0.6 нэгж хувь, 6 - 12 сарын дараах төсөөллийн зөрүү дунджаар 1.8-2.1 нэгж хувь болж байна. Гадаад, дотоод орчин туйлын тогтворгүй байгаа энэ үед улирал бүр нөхцөл байдал өөрчлөгдөж богино дунд хугацааны төсөөлөлд багагүй өөрчлөлт оруулан шинэчилж байгааг энд онцлон дурдах нь зүйтэй юм.

Хүснэгт 1. Мөнгөний бодлогын тайлангийн цахим холбоос

Он	Улирал	Тайлан	Төсөөллийн зөрүүг тайлбарласан хуудас
2026	II	Мөнгөний бодлогын тайлан	15
	I	Мөнгөний бодлогын тайлан	16
2025	IV	Мөнгөний бодлогын тайлан	15
	III	Мөнгөний бодлогын тайлан	15
	II	Мөнгөний бодлогын тайлан	16
	I	Мөнгөний бодлогын тайлан	15
	IV	Инфляцын тайлан	10

Он	Улирал	Тайлан	Төсөөллийн зөрүүг тайлбарласан хуудас
2024	III	Инфляцын тайлан	9
	II	Инфляцын тайлан	9
	I	Инфляцын тайлан	9

Эх сурвалж: Монголбанк

Хоёрдугаарт, Монголбанк мөнгөний бодлогын тайланд төсөөллийн зөрүү, өөрчлөлтийн талаар ил тод олон нийтэд зарлахаас гадна төсөөлөл шинжилгээний аргачлалаа тогтмол сайжруулж олон улсын сайн жишигт нийцүүлэн ажиллаж байна. Таны асуусан инфляцын 3, 6, 12 сарын дараах төсөөлөл буюу богино хугацааны төсөөлөлд хамаарах аргачлалыг сайжруулах ажилд Монголбанк сүүлийн жилүүдэд онцгой анхаарал хандуулж ажилласан. Тодруулбал, богино хугацааны төсөөлөл, шинжилгээ буюу 12 сар хүртэлх хугацааны төсөөллийг сайжруулах үүднээс 2022-2025 онд Олон Улсын Валютын Сангийн техник тусламжийн хүрээнд өндөр давтамжтай мэдээллийг төсөөлөлд нэвтрүүлэх, хамгийн сүүлийн үеийн сайн туршлага, аргачлалыг ашиглах, улирал бүрийн алдааны шинжилгээнд үндэслэн загварын жинг шинэчлэх, төсөөллийн үйл явцыг автоматжуулах замаар хүний нөөц, цаг хугацааг хэмнэх ажлуудыг хийж гүйцэтгэн, төсөл амжилттай хэрэгжүүлж дуусаад байна. Үүний үр дүнг танилцуулсан 39 хуудас бүхий тайланг Монголбанкны хамт олон ОУВС-ийн зөвлөхтэй хамтран боловсруулж, Олон Улсын Валютын Сангийн цахим хуудсанд [/Mongolia: Technical Assistance Report—Nowcasting and Near-Term Forecasting System/](#) 2026 оны 7 дугаар сард хэвлүүлсэн. Гол үр дүнгээр инфляцын богино хугацааны буюу 3, 6, 9, 12 сарын дараах төсөөллийн алдаа төсөл хэрэгжүүлэхээс өмнөх үетэй харьцуулахад харгалзан 37.5 хувь, 17.4 хувь, 14.0 хувь, 9.5 хувиар буурсан байна. Энэхүү тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хүснэгт 2: ОУВС-ын техник тусламжийн хүрээнд сайжруулсан богино хугацааны системийн үр дүнг өмнөх аргачлалтай харьцуулахад хэдэн хувиар сайжирсныг RMSE (хувиар) илэрхийлэв. Сөрөг утга хэдэн хувиар төсөөллийн алдаа буурсныг илтгэнэ.

	0	1	2	3
⁽¹⁾ Хэрэглээний үнийн индекс	-37.5	-17.4	-14.0	-9.5
⁽²⁾ Хэрэглээний үнийн индекс, доороос дээш	-26.0	-15.5	-7.8	1.2
Хонины мах	22.4	-10.5	-4.1	-1.3
Үхрийн мах	3.9	-21.5	-25.9	-22.8
Бусад мах	-15.3	0.4	-7.5	-17.7
	-35.3	-19.5	-19.1	-16.1
Гурил	-51.2	-20.4	0.1	22.0
Хүнсний ногоо	-7.4	-6.5	-9.0	-8.9
Импортын бараа	-26.8	-23.2	-25.7	-16.6
Дотоодын бараа	-60.6	-4.5	47.8	99.5
Үйлчилгээ	-52.4	-24.4	-21.0	-16.9

Тайлбар: Энэхүү хүснэгтэд богино хугацааны төсөөллийн, 1–4 улирал хүрээнд Монголбанкны мэргэжилтнүүдийн төсөөллийн RMSE болон загварын RMSE-ийн харьцангуй хувийн зөрүүг харуулсан. 2018 оны IV улирлаас 2023 оны III улирал хүртэлх хугацааг хамруулан хийж гүйцэтгэв.

Хүснэгт 3. Инфляцын төсөөлөл, гүйцэтгэлийн зөрүү, түүний гол шалтгаан

		2023	2024				2025				2026			
		IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III*	IV*
2024	I	9.1%	7.9%	7.5%	7.9%	8.0%								
	II		7.4%	6.0%	6.6%	6.4%	7.3%							
	III			5.5%	5.5%	6.3%	6.9%	7.5%						
	IV				5.9%	7.5%	8.5%	9.2%	9.5%					
2025	I					8.0%	10.7%	12.1%	12.4%	10.9%				
	II						9.2%	9.1%	8.5%	9.1%	8.6%			
	III							8.4%	8.4%	8.8%	8.1%	7.3%		
	IV								8.7%	8.3%	7.4%	8.2%	8.2%	
2026	I									8.3%	7.5%	8.2%	8.3%	7.5%
	II										7.1%	11.0%	11.1%	10.2%
		Төсөөлөл												
		Гүйцэтгэл												

Тайлбар: Мөрөөр төсөөллийн гүйцэтгэл болон төсөөллийн хугацааг, баганаар төсөөлөл боловсруулсан үеийг харуулав. Хөх өнгөөр бодит гүйцэтгэл, саарал өнгөөр суурь төсөөллийг тус тус тэмдэглэв.

Монголбанк нь 12 сар хүртэлх төсөөлөл буюу богино хугацааны төсөөлөл шинжилгээний системээ сайжруулахын зэрэгцээ дунд хугацааны төсөөлөл, шинжилгээг сайжруулах ажлыг жил бүр зохион байгуулан ажиллаж байна. Дунд хугацааны хагас бүтцийн “GAP” загварыг 2012 оноос хойш тасралтгүй хөгжүүлж байгаа бөгөөд сүүлийн байдлаарх /2026 оны 7 сар/ алдааны шинжилгээг тогтмол хийдэг. Мөн энэхүү дунд хугацааны төсөөлөл шинжилгээний загварын суурь ойлголтыг агуулсан “Мөнгөний бодлогын шинжилгээ GAP загвар” судалгааны ажлыг боловсруулж 2014 онд Монголбанкны судалгааны товхимолд хэвлүүлэн олон нийтэд нээлттэй байршуулсан ба уг судалгааг https://www.mongolbank.mn/mn_research/190 цахим холбоосоор хүргүүлж байна. Дунд хугацааны GAP загварын коэффициент болон загварчлалыг жил бүр тогтмол шинэчлэн сайжруулдаг бөгөөд энэ онд хийгдсэн сайжруулалтын үр дүнд загварын алдаанд гарсан өөрчлөлтийг дараах хүснэгтэд орууллаа. Уг хүснэгтээс дунд хугацааны төсөөллийн алдаа дунджаар 10 орчим хувиар буурсан байна.

Хүснэгт 4. GAP загварын шинэчлэлийн үр дүнд гарсан төсөөллийн алдааны өөрчлөлт, өмнөх загвартай харьцуулахад

		q1	q2	q3	q4	q5	q6	q7	q8
Инфляц	Сайжруулсан загвар	-9.1%	-5.5%	-10.5%	-10.2%	-10.5%	-9.3%	-9.8%	-12.2%

Эх сурвалж: Монголбанк

- 2026 оны 5 дугаар сард инфляц 11.2 хувьд хүрсэн байхад Мөнгөний бодлогын хороо 6 дугаар сарын 23, 24-ний өдрийн хурлаар бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалсан боловч 8 дугаар сарын 12-нд ээлжит бусаар хуралдаж бодлогын хүү болон заавал байлгах нөөцийг

нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор 6 дугаар сарын 24-өөс 8 дугаар сарын 12-ны хооронд инфляц, үнийн өсөлтийн дам нөлөө, инфляцын хүлээлтийн талаарх өмнөх үнэлгээг оорчлоход хүргэсэн мэдээлэл, үзүүлэлт, 11.2 хувийн инфляцыг түр зуурын шинжтэй гэж үзсэн үндэслэл, нэмэлт арга хэмжээ авах шаардлага хэзээ үүссэн гэж үзсэн болон уг арга хэмжээг өмнө авах боломж байсан эсэхэд хийсэн үнэлгээний талаарх холбогдох судалгаа, тооцоо, мэдээлэл, шийдвэрийн үндэслэл, тайлбар.

Мөнгөний бодлогын хэрэгслүүд нь банк хоорондын захын хүү, зээл, хадгаламжийн хүү, дотоод эрэлтийг өөрчлөх замаар эрэлтийн шалтгаантай инфляцад нөлөөлөх боломжтой байдаг. Харин нийлүүлэлтийн шалтгаант инфляцын анхдагч шалтгаан болох хүнс, шатахууны үнийн өсөлтийг мөнгөний бодлогоор шууд бууруулах боломж хязгаарлагдмал юм. Иймд нийлүүлэлтийн шокийн үед мөнгөний бодлогын гол зорилго нь үнийн анхдагч өсөлтийг шууд сааруулах бус, харин түүний хоёрдогч нөлөөг хязгаарлах, инфляцын хүлээлтийг тогтворжуулах, улмаар инфляц улам бүр эрчимжихээс сэргийлэхэд оршино.

Мөнгөний бодлогын хорооны 2026 оны 6 дугаар сарын 23-24-ны өдрийн МБХ-ны хурлаар инфляц хамгийн сүүлийн мэдээлэл болох 5 дугаар сард улсын хэмжээнд 11.2 хувьд хүрсэн хэдий ч мөнгөний бодлогоор нөлөөлөх боломжтой үнийн өсөлтийг илэрхийлэх суурь инфляц 5.8 хувь буюу Төв банкны зорилтын голчийн орчимд байв. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас авсан шатахууны импортын үнэ энэ оны үлдсэн хугацаанд өөрчлөгдөхгүй гэсэн мэдээлэлд үндэслэн шатахууны үнийг тогтвортой байхаар таамагласан. Түүнчлэн, шатахуун болон хүнсний инфляц оны сүүлийн хагаст саарах, мөн суурь инфляц зорилтын интервалд байх төсөөлөлтэй байв. Иймд, мөнгөний бодлогоор шатахуун, хүнс зэрэг нийлүүлэлтийн шалтгаант үнийн шууд өсөлтөд нөлөөлөх боломж хязгаарлагдмал бөгөөд эдгээр үнийн өсөлт нь түр зуурын шинжтэй, цаашид үнийн өсөлт саарах төсөөлөлтэй, 2026 оны 1-р улирлын иргэдийн инфляцын хүлээлт харьцангуй тогтвортой байсныг харгалзан Мөнгөний Бодлогын Хороо бодлогын хүүг хэвээр хадгалахаар шийдвэрлэсэн.

Харин 6 дугаар сарын шийдвэрийн дараа нийлүүлэлтийн шок түр зуурын шинжтэй байх тухай өмнөх таамаглал суларч, шатахууны үнэ дахин өсөх, усны үнэ нэмэгдэх, махны нийлүүлэлтийн саатал үргэлжлэх, инфляцын хүлээлт огцом нэмэгдэх зэрэг мэдээлэл зэрэгцэн гарснаар бодлогын үнэлгээг шинэчлэх шаардлага үүссэн. Үүнд:

1. 2026 оны 7 дугаар сард шатахууны үнэ дахин нэмэгдэж, инфляцад 0.3 нэгж хувийн нэмэлт шууд нөлөөг үзүүлсэн. Түүнчлэн шатахууны үнэ 8-9 сард үргэлжлэн өсөх, оны үлдсэн саруудад үнэ өсөж болзошгүй хүлээлттэй болсон.
2. Засгийн газрын тогтоолоор 2026 оны 6 дугаар сараас цэвэр, бохир усны үнэ 37 хувиар, 53 хувиар тус тус нэмэгдсэн.
3. Төвийн бүсэд шүлхий өвчний тархалт нэмэгдэж, вакцинжуулалт хийснээр махны нийлүүлэлт хот, суурин газарт хязгаарлагдсан тул махны үнэ улирлын хандлагаасаа 1 сар орчмын хойно буюу 7 дугаар сарын 20-ноос хойш буурч эхэлсэн.
4. Шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалан хэрэглээний сагсанд багтдаг Приус-41 автомашины үнийн жилийн өсөлт 7 дугаар сард өмнөх сараас 4.3 нэгж хувиар өссөн.


Эдгээр үнийн өсөлтийн нийлбэр нөлөөгөөр 6 дугаар сард 12 хувь байсан инфляц 7 дугаар сард 13 хувь болж, 1 нэгж хувиар нэмэгдэхэд 0.7 нэгж хувийн нэмэлт шууд нөлөө үзүүлсэн. Харин эдгээр өсөлтийн дам нөлөөгөөр энэ оны эцэст инфляцын төсөөлөл 1.2 нэгж хувиар нэмэгдсэн. Шатахууны үнийн өсөлт үргэлжилж байгаа нь бүх бараа, үйлчилгээний өртгийг нэмэгдүүлэх дам нөлөө өндөртэй

байдгаас суурь инфляцыг илүү удаан, өндрөөр нэмэгдүүлэх нөлөө үзүүлэхээр байна. Үүний зэрэгцээ 2026 оны 2 дугаар улирлын Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаагаар 1 улирлын дараах инфляцын хүлээлт 7.9 хувиас 12.0 хувь, 1 жилийн дараах хүлээлт 8.9 хувиас 12.5 хувь болж огцом өссөн байна. Мөн гадаад орчинд эрчим хүчний үнийн өсөлтөөс үүдэн дэлхий даяар үнийн дарамт нэмэгдэж, инфляц зорилтоос давснаас гадаад хүү өсөх хүлээлтээс шалтгаалан төгрөгийн өгөөж буурах эрсдэлтэй болсон.

Эдгээр гадаад болон дотоод суурь төсөөллийн таамаглалт нөхцөлд гарсан өөрчлөлтөд үндэслэн шинэчлэн боловсруулсан төсөөллөөр эрэлтийн шалтгаант инфляцыг илэрхийлэх суурь инфляц ирэх оны эхний улирлаас зорилтын интервалаас давах эрсдэлтэй болсон. Ийнхүү Мөнгөний бодлогын хороо иргэдийн инфляцын хүлээлтийг тогтворжуулах, нийлүүлэлтийн шалтгаант үнийн өсөлтийн 2 дах үеийн нөлөөг бууруулах зорилгоор 8 дугаар сард ээлжит бусаар хуралдаж:

1. Бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 12.5 хувьд хүргэх;
2. Банкнуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 0.5 нэгж хувиар өсгөж, 14.5 хувьд хүргэх шийдвэрийг гаргалаа.

Зураг 2. Иргэдийн инфляцын хүлээлт болон инфляцын суурь төсөөлөл




Эх сурвалж: Монголбанк

4. 2024 оны 9 дүгээр сард Монголбанк инфляц, дотоод эрэлт, зээлийн өсөлтийн эрсдэлийг анхааруулсан нөхцөлд бодлогын хүүг 11 хувиас 10 хувь болгон бууруулж, төгрөгийн заавал байлгах нөөцийг 2 нэгж хувиар нэмэгдүүлсэн бодлогын хосолсон шийдвэр инфляц, зээл, дотоод эрэлтэд ямар нөлөө үзүүлсэн, бодит гүйцэтгэл гарсны дараа уг шийдвэрт хийсэн дотоод үнэлгээ, тухайн шийдвэр оновчтой байсан эсэх талаарх өнөөгийн дүгнэлт, үнэлгээний алдаа гарсан бол түүнд үндэслэн авсан арга хэмжээний талаарх холбогдох судалгаа, тооцоо, мэдээлэл, дотоод үнэлгээ, тайлбар;

Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үед жилийн инфляц 2024 оны 8 дугаар сард Улаанбаатар хотын хэмжээнд 5.8 хувь, улсын хэмжээнд 6.1 хувь буюу зорилтын голчийн орчимд байв. Засгийн газрын шийдвэрээр цахилгаан, дулааны үнийн өөрчлөлт зэрэг нийлүүлэлтийн хүчин зүйлээс шалтгаалан инфляц бага зэрэг нэмэгдэх төлөвтэй байсан хэдий ч зорилтот интервалд хадгалагдах төсөөлөлтэй байсан. Эдийн засгийн өсөлтийн хувьд 2024 онд 5.5 хувь буюу потенциал өсөлтийн түвшинд хадгалагдах төлөвтэй байсан хэдий ч уул уурхайн бус салбарын өсөлт сул байв.

Эдийн засгийн гадаад орчны хувьд БНХАУ-ын эдийн засаг 5 орчим хувиар өсөж, гадаад эрэлт тогтвортой байх, гадаад инфляц харьцангуй нам түвшинд байх төлөвтэй байснаар томоохон төв банкууд бодлогын хүүгээ бууруулах хүлээлттэй байсан. Ийнхүү инфляцын цаашдын төлөв зорилтот интервалд хадгалагдах, эдийн засгийн өсөлт потенциал түвшинд байх, гадаад орчны төлөв харьцангуй таатай байхаар хүлээгдэж байсан тул мөнгөний бодлогын төлөвийг тодорхой хэмжээгээр зөөлрүүлэх орон зай бүрдсэн гэж үзсэнээр Мөнгөний бодлогын хороо 2024 оны 9 дүгээр сарын ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах шийдвэр гаргасан.

Хэдийгээр бодлогын хүүг бууруулсан хэдий ч санхүүгийн салбарын эрсдэл өндөр байж, зээл, санхүүжилтийн нөхцөлийг чангаруулах шаардлага үүсээд байв. Банкны салбарын зээлийн өсөлт эрчимжиж эхэлсэн нь хэрэглээний импортыг урамшуулах, дотоод эрэлтийг өдөөх, цаашлаад санхүүгийн салбарт мөчлөгийн эрсдэл хуримтлуулах эрсдэлтэй байсан (Зураг 3). Тодруулбал, 2024 онд банкны зээлийн жилийн өсөлт 33.7 хувь, хэрэглээний зээлийн жилийн өсөлт 36.5 хувьд хүрч огцом өсөөд байв. Заавал байлгах нөөцийн хувийг нэмэгдүүлэх нь банкнуудын хөрвөх актив буюу зээл гаргах боломжит эх үүсвэрийг хумьж, зээлийн өсөлтөд түргэн хугацаанд нөлөөлнө. Харин бодлогын хүү нь мөнгөний зах, зээлийн хүүгийн сувгаар дамжиж эдийн засагт үзүүлэх нөлөө 4-6 улирлын дараа бүрэн гардаг.




Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Улаан өнгө нь төгрөгийн ЗБН-ийн шийдвэр, ногоон өнгө нь гадаад валютын ЗБН-ийн шийдвэр, сумны чиглэл нь өсгөх болон бууруулсныг илтгэнэ.

Эдгээр шийдвэрийг гаргаснаас хойш ипотекийн зээлээр баталгаажсан бондыг оруулж тооцсон зээлийн жилийн өсөлт 2024 оны 3 дугаар улиралд 31.3 хувиас 2025 оны 3 дугаар улиралд 22.1 хувьд хүрч саарсан (Зураг 4). Зээлийн зориулалтаар нь авч үзвэл, хэрэглээний зээлийн өсөлт 37.4 хувиас 16.0 хувьд хүрч эрчтэй саарсан бол бизнесийн зээлийн өсөлт 30.5 хувиас 26.4 хувьд хүрч илүү алгуур саарсан байна. Ийнхүү зээлийн өсөлт саарч байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарахад тодорхой хэмжээнд нөлөөлсөн. Зээлийн өсөлтөөс гадна, гадаад валютын цэвэр гарах урсгалтай холбоотой банкны системийн гадаад цэвэр актив буурснаар 2024 оны 3 дугаар улиралд 24.5 хувьд хүрээд байсан мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2025 оны 3 дугаар улиралд 6.2 хувьд хүрчээ.

Нөгөө талаас инфляц цахилгаан, ус, дулаан, нийтийн тээвэр зэрэг төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн өсөлтөөс гадна төсвийн тэлэлт, цалингийн өсөлт, төсвийн хөрөнгө оруулалт, томоохон төслүүд зэрэг эрэлтийн шалтгаанаар инфляц эрчимжих эрсдэл нэмэгдэв. Иймд Мөнгөний бодлогын хороо 2025 оны I-р улирлын ээлжит хурлаар бодлогын хүүг 2 нэгж хувиар өсгөх шийдвэр гаргасан. Түүнчлэн хэрэглээний зээлийн өсөлт өндөр, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх зорилгоор хэрэглээний зээлийн ӨОХ-ны дээд хязгаарыг 50 хувьд хүргэж бууруулах, ЗБН-ийн хувь хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг авав. Эдгээр бодлогын арга хэмжээний үр дүнд 2025 оны 2 дугаар сард 9.6 хувьд хүрч нэмэгдээд байсан инфляц 2026 оны 3 дугаар сард 7.3 хувь буюу инфляцын зорилтын интервалын дээд хязгаараас бага түвшинд хүрч буурсан бол суурь инфляц 4.8 хувьд хүрч саарав.

Зураг 4. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд болон инфляц



Тэмдэглэл: Улирлын инфляцыг улирлын эцсийн сараар оруулав.


Эх сурвалж: Монголбанк, YCX

- 2024-2026 онд зээл болон мөнгөний нийлүүлэлтийн өсөлт дотоод эрэлт, хэрэглээ болон импортод хэт дарамт учруулах эрсдэлийг Монголбанк хэзээ, ямар үзүүлэлтээр тогтоосон, уг эрсдэлийг хязгаарлах зорилгоор бодлогын хүүгээс гадна заавал байлгах нөөц, зээлд чиглэсэн зохицуулалт болон бусад арга хэмжээг ямар үндэслэлээр авч хэрэгжүүлсэн, эдгээр арга хэмжээний үр нөлөөг хэрхэн үнэлсэн талаарх холбогдох судалгаа, тооцоо, мэдээлэл, шийдвэрийн үндэслэл, тайлбар;

Иргэдийн нэрлэсэн цалин, орлогын өсөлтийг дагаад хэрэглээний зээлийн өсөлт 2023 оны сүүлээс эхлэн эрчимжиж, банкны салбарын зээлийн өсөлтийг нэмэгдүүлэхэд голлох нөлөөтэй байсан. Энэ нь инфляц, төлбөрийн тэнцлийн дарамтыг нэмэгдүүлж, санхүүгийн салбарт мөчлөгийн эрсдэл хуримтлагдах нөхцөлийг бүрдүүлсэн. Тодруулбал, 2024 оны 11 сарын байдлаар банкны зээлийн жилийн өсөлт 33.7 хувь, хэрэглээний зээлийн жилийн өсөлт 36.5 хувьд хүрч огцом өсөөд байв (Зураг 6). Иймд банкны хэрэглээний зээлийн өсөлт эрчимжиж, санхүүгийн мөчлөгийн эрсдэлийг нэмэгдүүлж байсантай холбоотойгоор Монголбанкнаас санхүүгийн системийн эрсдэлээс сэргийлэх, зээл санхүүгийн мөчлөгийг тогтворжуулах зорилгоор банкны хэрэглээний зээлийн өр, орлогын харьцаа (ӨОХ)-ны хязгаарлалтыг шат дараатай чангаруулав. Тухайлбал, 2024 оны 7 дугаар сард

ӨОХ-ны дээд хязгаарыг 55 хувь, 2025 оны 3 дугаар сард 50 хувь, 2026 оны 1 дүгээр сард 45 хувь болгон тус тус бууруулсан.

Эдгээр арга хэмжээний нөлөөгөөр 2025 оны 3 дугаар сараас эхлэн хэрэглээний зээлийн өсөлтийн нийт банкны зээлийн өсөлтөд үзүүлэх хувь оролцоо эрчимтэй буурч байна. Энэ оны 7 дугаар сарын байдлаар хэрэглээний зээлийн өсөлт өмнөх оны мөн үеэс 16.2 нэгж хувиар буурч 4.5 хувь, нийт банкны зээлд эзлэх хувь 30.2 хувиас 27.9 хувь болж, хэрэглээний болон бизнесийн зээлийн харьцаа зохистой түвшинд хүрч сайжраад байна (Зураг 6).



Эх сурвалж: Монголбанк, ҮСХ

Түүнчлэн, зээл, санхүүгийн мөчлөгийг удирдах буюу мөчлөгийн далайцыг бууруулах, банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор төгрөгийн болон валютын ЗБН-ийн хувийг нэмэгдүүлэх бодлогын шийдвэрүүдийг МБХ-ноос 2024-2026 онд гаргаж байв. Үүнд:

- 2024 оны 12 сар: Цалин, орлогын өсөлтийг дагаж зээлийн өсөлт эрчимжиж, инфляцыг өдөөх эрсдэл хуримтлагдаж байсан тул төгрөг, валютын ЗБН-ийн хувь хэмжээг тус бүр 1 нэгж хувиар өсгөв.
- 2025 оны 1 сар: Эдийн засгийн өсөлтийг дагаж, төсөв тэлснээр иргэдийн цалин, орлого нэмэгдэж, зээлийн өсөлт өндөр хадгалагдаж байсан нь мөчлөгийн эрсдэлийг нэмэгдүүлж байсан бөгөөд гадаад орчны тодорхой бус байдлыг харгалзан төгрөг, валютын ЗБН-ийн хувийг тус бүр 2 нэгж хувиар өсгөв.
- 2026 оны 1 сар: Зээлийн өсөлт өндөр байгаа нөхцөлд төрийн албан хаагчдын цалин нэмэгдэх нь хэрэглээний зээлийн эрэлтийг эрчимжүүлэх, улмаар инфляц, төлбөрийн тэнцэлд үзүүлэх дарамт, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдах нөхцөлийг харгалзан төгрөг, валютын ЗБН-ийн хувийг тус бүр 1 нэгж хувиар өсгөсөн.

2026 оны 6 дугаар сарын байдлаар зээл, ДНБ-ий харьцааны урт хугацааны трендээс зөрөх зөрүү (Credit-to-GDP gap) буурч, улмаар санхүүгийн мөчлөг 2025 оны IV дүгээр улирлаас буурах чиглэлд шилжиж, тайлант улиралд тэнцвэрт түвшнээс бага зэрэг доогуур түвшинд хүрээд байна. Ийнхүү санхүүгийн мөчлөг буурч эхлэхэд зээлийн өсөлтийн сааралт голлон нөлөөлж байна (Зураг 5).


Түүнчлэн, сүүлийн улирлуудад банкнуудын нийт эх үүсвэрт гадаад санхүүжилтийн эзлэх хувь өсөж, зээлийн санхүүжилтийг гадаад эх үүсвэрээр нэмэгдүүлэх хандлага ажиглагдах болсон. Иймд гадаад

эх үүсвэрийн бүтцийг илүү урт хугацаатай, тогтвортой чиглэлд шилжүүлэх, валютын болон хугацааны зөрүүг бууруулах зорилгоор 1-3 жилийн хугацаатай гадаад эх үүсвэрийг гадаад валютын ЗБН-ийн шаардлагад хэсэгчлэн, үе шаттайгаар хамруулах шийдвэрийг 2026 оны 4 дүгээр сард МБХ-ноос гаргав. Өмнө нь Ковид-19 цар тахлын нөлөөг харгалзан 2022 оноос банкнуудын гадаад санхүүжилт татах сонирхлыг дэмжих зорилгоор гадаад зах зээлээс татсан дээрх эх үүсвэрийн үлдэгдлийг бүхэлд нь ЗБН-ийн шаардлагаас хасах түр хугацааны зохицуулалт хэрэгжүүлж байсан юм. МБХ-ны энэхүү шийдвэр гарснаас хойш банкнуудын богино, дунд хугацаатай гадаад санхүүжилтийн хэмжээ эрчимтэй буурч, урт хугацаат эх үүсвэрийн хэмжээ нэмэгдэж байна. Гадаад орчин тодорхойгүй, гадаад санхүүжилтийн зардал, хүртээмж богино хугацаанд өөрчлөгдөх, хөрөнгийн урсгалын төлөвийг өөрчилж болзошгүй өнөөгийн нөхцөлд энэ нь чухал бодлогын хариу арга хэмжээ юм.

Монголбанкнаас 2024 оноос 2026 онуудын хооронд иргэдийн зээлийн хэт өсөлтийг бууруулах зорилгоор бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн бөгөөд үүнд тэтгэврийн зээлийн зохицуулалтууд мөн багтаж байна. Тухайлбал:

2025 оны I хагас:

- Тэтгэврийн зээлийн хэт өсөлтийг сааруулах, тэтгэвэр авагчдын төлбөрийн чадварыг хамгаалах зорилгоор ГБХНХЯ-ны саналыг харгалзан 2025 оны 3 дугаар сард Монголбанкны МБХ-ны шийдвэрээр шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх тэтгэврийн зээлийн хувьд “сарын төлбөрийг төлсний дараах үлдэх орлого нь амьжиргааны доод түвшнээс багагүй байх” зохицуулалтыг мөрдүүлж эхэлсэн. Улмаар МБХ-ны 2025 оны 6 дугаар сарын хуралдаанаар өмнөх зохицуулалтыг зөөлрүүлж, тэтгэврийн зээлийн ӨОХ-ны дээд хязгаарыг 50 хувиар тогтоох буюу тэтгэврийн зээлийг бусад төрлийн хэрэглээний зээлтэй ижил зохицуулалттай байхаар шийдвэрлэсэн юм. Эдгээр арга хэмжээний үр дүнд тэтгэврийн зээлийн үлдэгдэл 2025 оны 3-6 дугаар сарын хооронд 312 тэрбум төгрөгөөр буурч, 1.7 их наяд төгрөг хүрч байв (Зураг 8).



Эх сурвалж: Монголбанк

2025 оны II хагас:

- Зээл авах боломжийг нь хязгаарлаж, хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байгаа талаар иргэдээс ирүүлсэн гомдол, УИХ-ын Эдийн Засгийн Байнгын Хороо, УИХ-ын гишүүдээс

ирүүлсэн чиглэл, удирдамж, Монгол Улсын Засгийн газрын зөвлөмжийг харгалзан үзээд Монголбанкны МБХ 2025 оны 7 дугаар сард тэтгэврийн зээлийн ӨОХ-ны хязгаарлалтыг хүчингүй болгож, мөн оны 12 дугаар сард тэтгэврийн зээлийн нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор:

- тэтгэврийн зээлийн эрсдэлийн жинг 150 хувиас 100 хувь болгон бууруулах,
 - тэтгэврийн зээлийн үлдэгдэлтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг заавал байлгах нөөц (ЗБН) тооцох эх үүсвэрээс хасах,
 - зээлдэгчдийн тэтгэврийн зээлийн үлдэгдлийг нэмэгдүүлэхгүйгээр, зээлийн нийт хугацааг 36 сараас хэтрэхгүй байхаар нэг удаа сунгаж, тус сунгасан хугацаагаар сарын төлбөрийн дарамтыг бууруулсан тохиолдолд уг активыг бүтэц өөрчлөгдсөн активт тооцохгүйгээр, эцсийн ангиллыг хэвээр хадгалах зэрэг багц арга хэмжээг хэрэгжүүлсэн.
- Дээрх шийдвэрийн дараа тэтгэврийн зээлийн өсөлт эргэн эрчимжиж, 2026 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар тэтгэврийн зээлийн үлдэгдэл өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 48.7 хувиар өсөж, 3.2 их наяд төгрөгт хүрээд байна. Энэ нь банкны системийн нийт зээлийн багцын 6.5 хувь, хэрэглээний зээлийн 23.6 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд сүүлийн улирлуудад банкны нийт хэрэглээний зээлийн өсөлтийн гол шалтгаан болж байна (Зураг 7, Зураг 8).

- 6. 2024-2026 оны төсвийн бодлого, төсвийн зарлагын тэлэлт дотоод эрэлт болон инфляцад хэдий хэмжээний нэмэлт дарамт үзүүлсэн талаарх Монголбанкны тооцоо, уг дарамтыг мөнгөний бодлогын зорилтод эрсдэл учруулах түвшинд хэзээ хүрсэн гэж үнэлсэн, энэ талаар Засгийн газар, Сангийн яам, Улсын Их Хуралд хүргүүлсэн санал, анхааруулга, бодлогын зөвлөмжийн талаарх холбогдох судалгаа, тооцоо, албан мэдээлэл, тайлбар;**

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт сэргэж, уул уурхайн экспортын орлого нэмэгдсэнээр төсвийн орлого хурдтай өссөн. Улмаар, төсвийн зардал эрчтэй нэмэгдэж¹, урьдчилан таамаглах аргагүй гэнэтийн өөрчлөлтүүд орж байсан нь инфляцын дарамтыг нэмэгдүүлэхээс гадна дотоод эдийн засгийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, макро эдийн засгийн төсөөлөл боловсруулах, мөнгөний бодлого хэрэгжүүлэхэд багагүй сорилт учруулсан. Төсвийн зардал өссөнөөр дотоод эрэлтийг өдөөх, импортыг нэмэгдүүлж валютын ханш сулрах дарамтыг нэмэгдүүлэх, улмаар нийт инфляцын дарамтыг нэмэгдүүлэх нөлөөтэй. Иймд Монголбанкны зүгээс нэгдсэн төсөвт гарч буй аливаа өөрчлөлтүүдийн инфляцад үзүүлэх дарамтыг тухай бүр тооцоолж, бодлогын шийдвэртээ харгалзан үздэг.

Тус нөлөөллийг тооцохдоо төсөөлөлд авч үзэж буй төсвийн зардлын дүн өмнөх таамаглалаас хэрхэн өөрчлөгдөж буй зөрүүгээр нь инфляцад үзүүлэх нэмэлт дарамтыг хэмжих бөгөөд тооцоололд тухайн үед ашиглах боломжтой бүхий л тоон болон чанарын мэдээллийг ашиглан, холбогдох таамаглал болон эдийн засгийн агентуудын хариу үйлдэлд гарах өөрчлөлт зэргийг тооцсоны үндсэн дээр төсөөллийг шинэчилдэг. Мөн тус тооцооллын үр дүн нь тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын эдийн засгийн төлөв, түүнчлэн төсвийн зардлын өсөлтийн хэмжээ, бүтэц, бүрэлдэхүүнээс хамааран эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь харилцан адилгүй байна.

Төсвийн тэлэх бодлого, зардлын өсөлтүүд нь инфляцад хэр хэмжээний дарамт үзүүлэх талаар 2023-2026 онуудад хийж байсан зарим тооцооллуудыг дурдвал:

¹ Нэгдсэн төсвийн нийт зардал 2023-2025 онд дунджаар 20.6 хувиар өссөн.

- 2023 оны 6 дугаар сарын төсвийн тодотголоор төсвийн нийт зардал батлагдсан дүнгээс 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдсэн. Үүнээс, 1.4 их наяд төгрөгийн зардал нь төрийн албан хаагчдын цалин, иргэдийн тэтгэвэртэй холбоотой байв². Монголбанкнаас 2023 оны 3 дугаар улиралд хийсэн тооцооллоор төсвийн зардал ийнхүү нэмэгдсэнээр дотоод эрэлтийг эрчимжүүлж, эдийн засгийн өсөлт 2024 онд суурь төсөөллөөс 0.3 нэгж хувиар нэмэгдэх бол нөгөө талаас эрэлтийн шинжтэй инфляцын дарамт нэмэгдэх, ханш сулрах нөлөөгөөр инфляц 2024 оны эцэст суурь төсөөллөөс 1.5 нэгж хувиар нэмэгдэх тооцоололтой байв.
- Мөн 2023 оны 11 дүгээр сард батлагдсан 2024 оны төсвийн төсөлд төрийн албан хаагчдын цалинг 2024 оны 4 дүгээр сараас өсгөхөөр³ тусгасан. Ийнхүү 2023-2024 оны цалингийн өсөлттэй холбоотой улсын секторын цалингийн өсөлт 2024 онд 50 орчим хувьд хүрэхээр байгаа нь хувийн секторын цалин өсөх дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байв. Улмаар, хувийн секторын цалин улсын секторын цалингийн өсөлтийг даган 20 орчим хувиар өсөх тохиолдолд эрэлтийн шалтгаанаар инфляц хурдтай нэмэгдэж, нийт цалингийн өсөлтийн инфляцад үзүүлэх нөлөө 2024-25 оны эцэст харгалзан 1.7, 1.5 нэгж хувь байх тооцооллыг 2024 оны 1 дүгээр улиралд боловсруулсан.
- Цаашлаад, 2024 оны 8 дугаар сарын “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн 2024 оны төсөвт тодотгол хийж, тус тодотголыг 2024 оны 8 дугаар сарын 30-нд баталсан. Үүнд, 2024 оны төсвийн зардал батлагдсан дүнгээс 3.1 их наяд төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд энэ нь инфляцад 1.5 нэгж хувийн нөлөө үзүүлэхээр тооцож байв. Тус төсвийн тодотголтой хамт өргөн баригдсан төсвийн хүрээний мэдэгдэлд ирэх онуудын зардал мөн нэмэгдсэн. Тухайлбал, 2025 оны төсвийн зардал өмнөх төсвийн хүрээний мэдэгдлийн дүнгээс 2.9 их наяд төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд төсвийн зардал ийнхүү нэмэгдэх нь инфляцыг 2025-2026 оны эцэст 1.3 нэгж хувиар, 0.4 нэгж хувиар нэмэгдүүлэхээр байв.
- Гэвч, эдгээр мега төслүүдийг ямар эх үүсвэрээр санхүүжүүлэх, жилд хэдэн төгрөгийн санхүүжилт хийгдэх зэрэг нь тухайн үед тодорхойгүй байсан тул холбогдох тооцооллуудыг хийхэд хүндрэлтэй байв. Улмаар, 2024 оны 12 дугаар сард Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Гашуунсухайт-Ганцмод болон Ханги-Мандал боомтын хил холболттой холбоотой 2024 онд 528 тэрбум төгрөг, 2025 онд 718 тэрбум төгрөг, 2026 оноос хойш 7.8 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдэхээр байгаа нь 2025 оны инфляцыг 0.9 нэгж хувь, 2026 онд 1.6 нэгж хувиар нэмэгдүүлэх тооцоолол боловсруулж байв.
- Хэдийгээр бусад төслүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй боловч, эдийн засагт үзүүлж болзошгүй эрсдэлийг тооцоолох үүднээс Ган татлагат гүүр болон Хөшигтийн хөндийн туннел гэсэн 2 төсөлд 2025-2027 онд нийт 1.8 тэрбум ам.долларын бүтээн байгуулалт хийгдэх⁴, тус бүтээн байгуулалтыг дотоод эх үүсвэрээс санхүүжүүлэх тохиолдолд гадаад валютын нөөцөд их хэмжээний дарамт учруулах, инфляцыг 2025-2026 онд 2-3 нэгж хувиар өсгөх, нэрлэсэн хүүг 3-3.5 нэгж хувиар нэмэгдүүлэх нөлөөтэй гэсэн тооцооллыг хийсэн.
- Түүнчлэн, 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр хэлэлцэн баталсан 2025 оны төсвийн тухай хуульд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 11

² 217.7 мянган төрийн албан хаагчдын цалинг 10-50 хувиар өсгөсөн.

³ Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалинг 20 хувиар, бусад төрийн төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэх

⁴ Эдгээр төслүүдийн нийт бүтээн байгуулалтын дүн 2.3 тэрбум ам.доллар гэж таамагласан.

дүгээр сарын 20-ны өдөр хориг тавьсан. Улмаар, Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж өргөн барьсан бөгөөд улмаар батлагдсан төсвийн зардал өмнөх дүнгээсээ 2.4 их наяд төгрөгөөр буурсан. Улмаар, инфляцад 1.2 нэгж хувийн бууруулах нөлөөтэй байв.

- Мөн 2025 оны 6 дугаар сард Засгийн газраас 2025 оны төсөвт тодотгол хийх төслийг боловсруулсан бөгөөд тус тодотголоор төсвийн орлогын бууралтаас шалтгаалан төсвийн зардал батлагдсан дүнгээс 1.9 их наяд төгрөгөөр буурсан. Төсвийн зардал ийнхүү буурсан нь 2025 оны инфляцыг 0.6 нэгж хувиар бууруулах тооцооллыг тухайн үед хийж байв.
- 2026 оны батлагдсан төсөвт 2026 оны 1 дүгээр сарын 1-нээс багш нарын цалинг дунджаар 50 хувиар өсгөх, 2026 оны 11 дүгээр сард багш нарын цалинг дахин 26 хувиар нэмэгдүүлэх, эмч, эмнэлгийн байгууллагын ажиллагсдын цалинг 15 хувиар нэмэгдүүлэх зэрэгт төсвийн цалингийн зардал нийт 709 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр тусгасан. Монголбанкны 2025 оны 4 дүгээр улиралд хийсэн тооцооллоор эдгээр цалингийн нэмэгдлийн нөлөө нь 2026 оны нийт инфляцыг 0.4-0.5 нэгж хувиар нэмэгдүүлэхээр байв.

Ийнхүү дийлэнх тохиолдолд төсвийн зардал тэлэх чиглэлд өөрчлөгдөж, инфляцын дарамтыг нэмэгдүүлсээр ирсэн нь мөнгөний бодлого сулрах орон зайг хязгаарлаж, бодлогын хүү өндөр түвшинд хадгалагдах суурь нөхцөл болсон.

Хэдийгээр Монголбанкнаас төсвийн бодлогын талаар Засгийн газар, Сангийн яам, Улсын Их Хуралд санал, анхааруулгыг албан бичиг байдлаар хүргүүлээгүй боловч төсвийн хэт тэлэлт, мега төслүүдтэй холбоотой тооцооллуудыг тухай бүрд боловсруулан Сангийн яамд холбогдох үр дүнг мэдээлэн, хамтран ажиллаж байв. Түүнчлэн, МБХ-ны хурлын мэдэгдэл, жил бүр УИХ-д өргөн барьдаг Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төсөл болон мөнгөний бодлогын тайлан, хэвлэлийн ярилцлага зэргээр дамжуулан төсвийн эрсдэлийн тухай олон нийт, бодлого боловсруулагчдад эрсдэлийг тогтмол анхааруулсаар ирсэн билээ. Тухайлбал, 2024 оны 3 дугаар сар, 12 дугаар сар, 2025 оны 1 дүгээр сар, 3 дугаар сар, 12 дугаар сарын мөнгөний бодлогын мэдэгдлүүдэд цалингийн өсөлт, төсвийн тэлэлтээс шалтгаалан инфляцын дарамт нэмэгдэж байгаа талаар удаа дараа дурдсан. Мөн мөнгөний бодлогын тайлангийн “1.2. Инфляцын төсөөллийг өөрчилж болзошгүй эрсдэлт хүчин зүйлс” хэсэгт зөвхөн төсөв гэлтгүй инфляцын цаашдын төлөвт нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, тэдгээрийн инфляцад үзүүлэх нөлөөллийг нэгтгэн боловсруулж, олон нийтэд хүргэдэг.

Монголбанкнаас жил бүр боловсруулан УИХ-д өргөн барьж буй Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийн тооцоо, танилцуулгад инфляцыг зорилтот түвшинд тогтвортой хадгалахын тулд төсөв хэт тэлсэн бодлого явуулахгүй байх, төсөв мөнгөний бодлогын уялдааг хангах нь чухал болохыг тогтмол онцолж ирсэн билээ. Тухайлбал, төсвийн зардал нэмэгдэхтэй холбоотой инфляцад бий болох эрсдэлийг хувилбар тооцоолоор боловсруулж, 2024, 2025 оны Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийн “4.6. Инфляцын гол эрсдэлүүдэд суурилсан хувилбар төсөөлөл” хэсэгт танилцуулж байв.


7. Монголбанкны тооцоогоор мөнгөний бодлогын арга хэмжээ дотоод эрэлт болон инфляцад хэдий хугацааны дараа, ямар хэмжээгээр нөлөөлдөг, 2026 оны 8 дугаар сарын 12-ны шийдвэр инфляцад хэзээнээс, ямар хэмжээгээр нөлөөлөхөөр тооцож байгаа талаарх холбогдох судалгаа, тооцоо, мэдээлэл, тайлбар;

Бодлогын хүүний өөрчлөлт нь инфляц болон эдийн засгийн өсөлт, дотоод эрэлтэд хэрхэн нөлөөлөхийг мөнгөний бодлогын шийдвэр гаргалтад ашиглаж буй загварын тооцооллоор Зураг -т үзүүлээ.

Бодлогын хүүг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын төлөвийг чангаруулах нь зах зээлийн хүү, валютын ханш, зээл болон хүлээлтийн сувгаар дамжин инфляц болон дотоод эрэлтийг бууруулах нөлөөтэй байна.

Макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүд өөрчлөлтгүй байх үед зөвхөн бодлогын хүүг 0.5 нэгж хувиар өсгөхөд инфляц аажмаар буурч, 5 улирлын дараа суурь инфляц 0.5 нэгж хувь, нийт инфляц 0.4 нэгж хувиар бууран, цаашид алгуур хэвийн түвшин рүү дөхөхөөр байна. Бодлогын хүүг өсгөх шийдвэрээс 5 улирлын дараа эдийн засгийн өсөлт 0.15 нэгж хувиар буурахаар байна (Зураг 9). Нөлөөллийг дэлгэрэнгүй байдлаар Хүснэгт 6-т орууллаа.

Зураг 9. Бодлогын хүүний өөрчлөлтийн үйлдвэртэл, инфляцад үзүүлэх нөлөө



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

Хүснэгт 6. Бодлогын хүүний өөрчлөлтийн үйлдвэртэл, инфляцад үзүүлэх нөлөөлөл

Макро үзүүлэлт	t_1				t_2				t_3			
	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV
Эдийн засгийн өсөлт (%)	0.02	0.02	-0.06	-0.12	-0.15	-0.14	-0.03	0.06	0.11	0.12	0.11	0.08
Нийт инфляц (%)	-0.06	-0.15	-0.25	-0.35	-0.39	-0.37	-0.32	-0.25	-0.18	-0.11	-0.06	-0.02
Суурь инфляц (%)	-0.06	-0.17	-0.30	-0.43	-0.48	-0.47	-0.41	-0.32	-0.22	-0.13	-0.06	0

Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2026 оны 8 дугаар сарын 12-ны өдөр ээлжит бусаар хуралдан бодлогын хүүг 0.5 нэгж хувиар, банкнуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 0.5 нэгж хувиар тус тус нэмэгдүүлэх шийдвэр гаргасан. Эдгээр шийдвэрүүд эдийн засагт хэрхэн нөлөөлөхийг доор тайлбарлав.

I. Бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж 12.5 хувь хүргэх

Бодлогын хүүг 2026 оны 8 дугаар сард 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж 12.5 хувьд хүргэхэд 2026 оны эдийн засгийн өсөлтөд нөлөө үзүүлэхээргүй байгаа бол 2027 онд эдийн засгийн өсөлтийг 0.2 нэгж хувиар сааруулах нөлөө үзүүлэхээр байна. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш 2026-2028 онд суурь төсөөллөөс харгалзан 11, 30, 36 орчим төгрөгөөр чанга тогтох төсөөлөлтэй байна. Эдийн засгийн өсөлт буурах, ханш чангарах нөлөөгөөр инфляц саарч, 2026-2027 оны эцэст инфляцыг 0.20, 0.66 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлэхээр байна.

II. Банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 14.5 хувьд хүргэх

Банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 14 хувиас 0.5 нэгж хувиар өсгөх бодлогын шийдвэр нь нийт зээлийн өсөлтийг 2026 онд 0.15 нэгж хувиар бууруулах бөгөөд зээлийн өсөлт саарах нь импортын өсөлтийг сааруулах замаар төлбөрийн тэнцэлд 2026 онд 12 сая ам.доллар, 2027 онд 18.5 сая ам.долларын эерэг нөлөөтэй байхаар байна. Улмаар төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн сулрах дарамт буурснаар ханш 2026 оны эцэст бага зэрэг чангарах, эдийн засгийн өсөлт 2026 онд суурь төсөөлөлтэй харьцуулахад 0.06 нэгж хувиар буурах нөлөө үзүүлэхээр байна. Эдийн засгийн өсөлт 2027 онд суурь төсөөллөөс 0.06 нэгж хувиар бага байх ба инфляц 2027 оны эцэст суурь төсөөллөөс 0.15 нэгж хувиар бага байх төсөөлөл гарлаа.

Заавал байлгах нөөцийн хувь хэмжээг нэмэгдүүлэх шийдвэрийн үр дүнд дотоод эрэлт 2026 онд өөрчлөлт багатай, суурь төсөөллийн орчимд байх бол 2027 онд 0.05 нэгж хувиар буурахаар байна.

- 8. Инфляц зорилтот түвшнээс мэдэгдэхүйц хазайсан үед бодлогын хариу арга хэмжээ хоцрох, төсөөлөл болон эрсдэлийн үнэлгээний алдаа давтагдахаас сэргийлэх зорилгоор инфляцын зорилтоос хазайлтын шалтгаан, Монголбанкны нөлөөлөх боломжтой хэсэг, авсан болон авах арга хэмжээг тусгайлан тайлагнах, эрсдэлийг эрт илрүүлэх үзүүлэлт болон бодлогын шийдвэрийг дахин үнэлэх шалгуурыг тодорхой болгох, төсөөллийн алдааг тогтмол үнэлж нийтэд мэдээлэх, Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийн тооцоо, үндэслэл, гол эрсдэлийг илүү нээлттэй болгох чиглэлээр хийхээр төлөвлөж буй өөрчлөлт, хэрэгжүүлэх хугацааны талаарх мэдээлэл, үндэслэл, төлөвлөгөө, тайлбар.**

